# ЦС Байгууллагат туслах хүчнүүдийн аймгийн зөвлөлгөөн

## Хэн, хаанаас ШАЛГАРАВ?

### Сайчууд шалгарчээ

ЦС байгууллагат туслах хүчнүүдийн аймгийн зөвлөлгөөнд ажил хөдөлмөр, амжилт бүтээлээрээ шалгаран оролцож, ажлынхаа арга туршлагыг хамтран солилцож байгаа сайчуудын зарим нэг хүний ажлын бүтээлээс уншигч олонд товч танилцуулъя.

Эрдэнэсант сумын АДХГ Захиргааны нарийн бичгийн дарга, сумын олон нийтийн бригадын штабын даргаар Б.Зангад ажилладаг.

Зангад олон нийтийн бригадын гишүүдийг,нэгдлийн үйлдвэрлэлийн нэгж бүрт хуваарлаж ажилладаг байна.

Бригадын ажлыг улирлаар төлөвлөж, бригадын гишүүдийн хурлыг улиралд нэг удаа хийж, урьд улирлын ажлыг дүгнэж дараа улиралд хийх ажлын төлөвлөгөөг баталдаг юм.

Эдний бригад зөвхөн энэ онд сумын төвийн албан газруудын харуул манааг 9 удаа шалгаж илэрсэн дутагдлыг тэр дор нь зассан байна.

Тэрчлэн манаач эд хариуцагч нарын зөвлөлгөөнийг 2 удаа хийлгэжээ.

Бригадын гишүүд,хууль дүрмийн 10 гаруй сэдвээр 20 гаруй газар ухуулга яриа хийж, үүнд давхарласан тоогоор 7000 гаруй хүн хамрагдсан байна.

Баянзүрх сумын ОНБ-ын гишүүн Л.Амьтан 61 өрх айл хариуцан ажиллаж тэдэнд хууль дүрэм сурталчилдаг. Амьтан энэ он гарсаар хууль дүрмийн 20 гаруй сэдвээр 36 удаа яриа таниулга хийсэн байна.

Амьтан нам, засгийн тогтоол шийдвэр, хууль, дүрэм сурталчлах самбар, булан байгуулж ухуулгын арвин их материал цуглуулсан юм.

Амьтангийн хариуцсан айл өрхөд сүүлийн 2 жилийн дотор гэмт хэрэг хэв журмын зөрчил гараагүй байна.

Баянцогт сумын ОНБ-ын гишүүн А.Гомбо холбооны салбарын эрхлэгчээр ажилладаг. Гомбо холбооны нэг өрөөнд хууль дүрэм сурталчлах булан байгуулжээ.

Энэ буландаа Ардын Их Хурлын 10 гаруй зарлигийн заалтыг бичиж тавьсан байна.

Гомбо энэ онд 18 хүн цагийн эргүүл хийж, эрүүгийн гэмт хэрэг нэгийг илрүүлсэн байна.

Гомбо хууль дүрмийн 30 шахам сэдвээр 1000 гаруй хүнд яриа таниулга хийж өөрийнхөө санаачлагаар хуучин материал ашиглаж радио хүлээн авагч хийж ухуулгынхаа ажилд хэрэглэж байна.

Их хайрханы уурхайн дэргэдэх орон тооны биш авто техникийн байцаагч З. Доржпалам уурхайн төвийн гудамж хөдөлгөөний замд 13 удаа эргэлт шалгалт хийж 59 машинд үзлэг хийсэн байна.

Жолооч нарт 34 удаа яриа таниулга хийсэн аж.

Энэ мэтийн тэргүүний ажиллагаатай 80 гаруй хүн аймгийн зөвлөлгөөнд оролцож байгаагийн дотор Зуунмод хотын ОНБ-ын гишүүн Лувсанжамц, Агваан-молом, Борнуурын Дагва,Их хайрханы Намсрай, Баянзүрхийн Намсрай нарын 13 хүн улсын зөвлөлгөөнд шалгараад байна.



ЦС байгууллагат туслах хүчнүүдийн аймгийн зөвлөлгөөнд 80 гаруй сайчууд шалгаран оролцож байна.

ЗУРАГ ДЭЭР: (Баруун гараас) Зуунмод хотын ОНБ—ын дарга Лувсангомбо, сэргийлэгч Гомбожав, Зуунмод хотын бригадын гишүүн Цэрэнпил нар ажлаа зөвлөж байна.

Манай сурвалжлагчийн авсан гэрэл зураг

## Сүүлчийн шуудангаар

Эрдэнэ сумын хэмжээгээр суурийн сургууль хүмүүжлийн ажил бүх суурьт нэгэн зэрэг эхлэв.

Суурийн сургуулийн багш нарыг семинарлан, сумын төвөөс 2—3 суурийн дунд 1 төлөөлөгч явуулан суурийн сургуулийг эхлүүлж, анхны нь хичээлийг заалгаж, цаашид хичээлийг яаж хийх талаар зөвлөлгөө өгүүлэв.

Д.Ёндон

* * *

Д.Нацагдоржийн төрсний 62 жилийн ойг тохиолдуулан аймгийн төвийн 10 жилийн дунд сургуулийн 7—гийн А, 10—ын Б ангиудаас хамтран «Д.Нацагдорж эх орноо магтан дуулагч» гэсэн сэдэвт үдэшлэг зохиов.

Уг үдэшлэгт их зохиолчийн амьдрал ба уран бүтээлтэй танилцах зорилгоор «Хи хи хи», «Цагаан сар ба хар нулимс»,«Үзэг дээгүй юм» зэрэг өгүүллэг болон «Би биш» хэмээх жүжгийн гол үйл явдлыг харуулсан богино хэмжээний үзэгдэл тоглов.

Ц.Батхүү

## Туслах хүчнүүдийн амжилт

Одоо аймгийн хэмжээгээр сум-нэгдэл, сум—СAA, томоохон үйлдвэрийн газруудын дэргэд олон зуун гишүүдийг хамарсан олон нийтийн бригад, штаб, хэдэн арван гишүүдтэй галын бүлгэм болон авто техникийн олон нийтийн байцаагч, өсвөрийн сэргийлэгчдийн бүлгэм зэрэг ЦС байгууллагат туслах олон тооны хүчнүүд ажиллаж байна.

Цагдан сэргийлэх байгууллагат туслах эдгээр хүчнүүд маань нам, засгийнхаа тогтоол шийдвэр, хууль дүрмийг хөдөлмөрчдөд ухуулгын аль ашигтай олон хэлбэрээр сурталчилж байна.

Ингэснээр нийт хөдөлмөрчид хуулийн байгууллагуудын холбоо улам бэхжиж, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд тавих олон түмний хяналт сайжирсаар байна.

Цагдан сэргийлэх байгууллагат туслах идэвхтнүүд аймаг, улсын зөвлөлгөөнийг угтаж зөвхөн энэ онд хууль дүрмийн олон сэдвээр 346 удаа 25400 хүнд яриа таниулга хийж, 214 удаа 3228 хүн цагийн эргүүл хийж, эрүүгийн гэмт хэрэг 3, танхай балмадын хэрэг 9, хэв журмын зөрчил 63—ыг илрүүлсэн байна.

Манай тусгай сурвалжлагч

## *Галын бүлгэмийн гишүүн*

Зуун мод хотын ҮХ Артелийн ажилчин, галын бүлгэмийн гишүүн Банзрагч нь өөрийн хариуцсан объёкт дээрээ галын аюулаас урьдчилан сэргийлэх тогтоол дүрэм заавруудыг ажилчин албан хаагч, хөдөлмөрчдөд тогтмол тайлбарлан таниулдаг юм.

Банзрагч зөвхөн болзлын хугацаанд өөрийн хариуцсан газартаа 17 удаа 2115 хүнд галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар яриа хийжээ.

Түүнчлэн н.Банзрагч нь өөрийн хариуцсан ажилдаа идэвхи зүтгэлтэй ажилладгийн дээр шинийг санаачлагч хүн юм.

Тэрээр гутал отлогч машин хийсний дээр өөрийн ажлын чөлөө заваар галын аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд Артелийнхаа модон тасагт гал түймрийн аюулгүй байлгах модны тоос сорогч, салхивч, галын багажийн модель зэргийг санаачлан хийсэн байна.

Ингэж ажилласнаар тэрээр ЦС байгууллагат туслах хүчнүүдийн улсын анхдугаар зөвлөлгөөнд оролцохоор шалгараад байна.

М.Бадарч

## Авто техникийн олон нийтийн байцаагч

Зуунмод хотын ҮХ Артелийн ажилчин Бал-очир гуай цагдан сэргийлэхэд туслах олон нийтийн бригадын тишүүн, авто техникийн олон нийтийн байцаагчаар ажиллаад хоёр жил гаруй болж байгаа манай тэргүүний гишүүдийн нэг юм.

Бал-очир гуай ЦС-д туслах хүчнүүдийн аймгийн зөвлөлгөөнийг угтаж хэв журам,социалист өмч хамгаалалтын талаар 129 удаа 4639 хүнд ухуулга хийв.

Мөн авто хөдөлгөөнийг зохицуулах дохионы мод, шүгэл зэргийг санаачлан хийсэн нь үр дүнтэй зүйл болсон юм.

Одоо Бал-очир гуай ажил үйлсээрээ шалгаран зөвлөлгөөнд оролцож байна.

П.Баатар

## *Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлээ хангав*

Баян сумын «Монгол—Польшийн найрамдал» нэгдэл мал аж ахуйн өвөлжилтийг 70 суурьт зохион байгуулан хийж худаг гаргах, хашаа барих төлөвлөгөөгөө 100 хувиар биелүүлж,хадсан 956 тонн өвсөө өвөлжөө,хаваржаандаа бүрэн татаж 34 хашаа засч, 31 худаг дулаалав.

Мөн сүрэл 55,3 тонн, ногоон тэжээл 28 тонн, таанын зоодой 22 мянган ширхэг, таанын дарш сорс 6,5 тонн,тарваганы ходоод 2450 ширхэг, хомоол 30,4 тонн, хуурай бууц 103 тонн бэлтгэн нөөцөлж бүх малынхаа 96,4 хувийг дундаас дээш тарга хүч авахуулан малдаа эрүүл мэндийн үзлэг хийж ядарсан малаа тэжээх, эмчлэх 4 цэг байгуулж тавтай өвөлжиж байна.

Энэ суурьудын дотроос Б.Батсүх, С.Алтангэрэл, О.Сандагдорж нарын суурь өвөлжилтийн бэлтгэлийг бусдаасаа илүү сайн хангав.

Д.Дашцэрэн

# Олны магтдаг хүн

*Сурвалжилсан тэмдэглэл*

Тус аймгийн олон суманд явж байхад аймгаас очсон хүмүүсээс Бүдбазарынхан сайн уу? мөд үүгээр ирэхгүй юм байхдаа гэж олон хүн хүсэмжилсэн байртай сураглана.

—Бүд ахыг гутал аваад түргэн ирээрэй гэж хэлээрэй! бид сургуульдаа удахгүй очно гэж хүүхэд багачуул захина.

Хүүгийнх гэр барих дөхчихлөө, чамд захисан юм л дутуу байна гэж хэлэхээр өөрөө мэднэ гэж өвгөд хөгшид ч ярьж л байдаг.

Энэ бол олонд өр алдчихсан хүний тухай өгүүлж байгаа бишээ! Олны хэрэгцээт барааг хүслий нь дагуу хангаж, захисан зүйлий нь гэрт нь очиж,гарт нь бариулж өгдөг нэг агентыг ингэж сураглaдаг юм.

Энэ агентыг ганцхан хөдөө ч биш, Зуунмод хотод оршин суугчид бас л сураглаж Бүдийнд ямар бараа ирж вэ?— Өө тэгвэл миний захисан зүйл ирсэн байх гэж өөр хоорондоо хүүрнэлдэн ярилцаж байхыг олонтой сонссон. Энэ хүн барааны захиалгыг аваад алга болчихдог хүн ч биш хэлсэн хугацаандаа ирж хүссэн бараагий нь худалдаж олныг баярлуулдаг юм.

Би олны магтдаг энэ хүнтэй саяхан уулзаж амжилт бүтээлтэй нь танилцсан билээ.

— Та ажлынхаа арга туршлагаас ярьж өгнө үү? гэхэд: Надад хүнд хэлээд байх туршлага байхгүй.

—Би үйлдвэрийн хоршооллын артельд нийтдээ 30 жил ажиллаж байна.

Сүүлийн 10 гаруй жилд нь артелийн бэлэн бараа борлуулдаг агент хийж байгаа юм.

Энэ хугацаанд өр дутагдал гаргаагүй жил дараалан бараа гүйлгээнийхээ төлөвлөгөөг давуулан биелүүлсэн.

—Би Бүрэн, Дэлгэрхаан сумын Артельд ажиллаж байгаад тэндэхийн артелиуд 1960 онд аймгийн төвд ирэхэд л энд ирсэн. Энэ хугацаанд Зуунмод хотоос гадна аймгийнхаа бүх сумаар худалдаа хийж яваад олон түмэнтэй ах дүү шигээ танилцсан юм.

Тэд маань ч ижил дасал болоод артелийн үйлдвэрлэж байгаа барааг намайг хийдэг юм шиг л олон төрлийн хэмжээтэй гутал хувцас, бараа таварыг өнгө зүсээр нь хүртэл захина.

Захиалсан бараагий нь олж өгөх гэж дарга, мастеруудтайгаа нилээд ярна болно.

Зарим материал байхгүй байхад тийм ийм юм хэрэгтэй гээд шалгааж байх юм.

Та ер нь үйлдвэрт хийгээгүй юмыг заавал олж өгнө гээд хүний мөнгө авчихаад артелиа өрөнд унагачихаад ирдэг хүн үү гэж зарим дарга нар ч цухалдаж зэмлэдэг байсан.

—Хаанаасдаа дарга минь олны хүссэн барааг олж өгөөгүй байж яалаа гэж мөнгий нь авдаг юм бэ? Ер нь хүний хэрэгцээг хангаж байгаа болохоор захисан бараагий нь манайх хийж, би хүргэж өгөх ёстой гэж хэлээд уурлуулчихаж байсан удаа бий.

Хэн ч гэсэн ялгаагүй хэрэгцээт бараагаа авах гэж бодно, тэр хүний хэрэглэх бараа надад байхгүй бол захиалгы нь аваад дараа ирэхдээ заавал өгдөг юм.

Харин манай энэ Нацаг дарга залуу хүндээ зохион байгуулах чадал сайтай, олон түмний эрэлт хүсэлтийг хангах талаар их анхаарч ажилладаг сайн хүн байгаа юм.

Бидний санал гомдлын дэвтэр дээр бичсэн зүйлийг сард нэг удаа шалган үзээд захиалсан барааг,хариуцаж байгаа мастеруудыг дуудаж ирүүлээд за танай тасаг төдөн зуух яндан, пийшин хий, танайх хөвөнтэй өмд, цамц, гарын бээлий төдийг хий. Танайх номын сан, тогооны шүүгээ төдийг хий,манайд захиалга ирсэн төчнөөн нэр төрлийн бараа байна гээд үүнийг түргэн хий гэж үүрэг өгдөг.

Уг барааг үйлдвэрээс гармагц бидэнд унаа хөсөг гаргаж явуулдаг юм.

Энэ бол төлөвлөгөө биелүүлэхэд их тус дөхөм үзүүлдэг.

—Манай хөдөөгийн малчин түмэн чадлынхаа хирээр хөдөлмөрлөж,хийсниийхээ хирээр цалин авдаг болохоор худалдан авах чадал нь жилээс жилд нэмэгдэж, хэрэгцээлэх бараа нэг адил өссөөр байна.

Бүр тодорхой баримтаар ярихад аймгийн хэмжээгээр сүүлийн жилүүдэд олон арван айл шинэ гэр барьж,доторхи тавилга төхөөрөмжийг дан шинээр авч тавьдаг болсноос гадна,том том хэмжээний хивс, радио хүлээн авагч, номын сан,цахилгаан угаалга, индүү, моторт дугуй зэрэг соёл техникийн барааг их авдаг болж байна.

Ийм үед агент хүн авхаалж самбаатай ажиллаж түмэн олныхоо хэрэгцээг хангаж, төлөвлөгөө нормоо биелүүлэх ёстой.

Манай аймгийн хорин хэдэн сумдын хөдөлмөрчид сум, сумаараа бараа таворын онцлог хэрэгцээтэй байдаг.

Нэг суманд эмэгтэйчүүд ногоон өнгөтэй дээл ижилсэх маягаар өмсдөг бол,нөгөө нэг суманд хүрэн өнгөтэйг өмсөх жишээтэй байдаг.

Үйлдвэрийн барааны агент хүн энэ бүгдийг сайн ажиглах хэрэгтэй юм гэж Бүдбазар ярьж байна.

Бүдбазар сайн агент төдийгүй сайн ухуулагч хүн. Бүдбазар үйлдвэрээс гарч байгаа барааны эдлэгдэх хугацаа,чанар байдлыг хөдөлмөрчдөд сурталчлахын хамт барааны үзэмж хийцэнд олон түмнээс өгсөн үнэлэлтийг нэг адил хүлээн авч үйлдвэрийнхээ захиргаанд мэдэгдэж, үйлдвэрийн барааны чанар чансааг сайжруулах талаар нэг адил анхаарч ажилладаг юм.

Энэ үеэр гаднаас нэг хүн орж ирээд мэндлэнгүүтээ Жаргалантын СААгаас танд энэ бичгийг өгөөрөй гэсэн юм гэхэд:

—За яамай ажилчдын хэрэгцээнд 50 хос хөвөнтэй өмд цамц, 200 ширхэг гарын бээлий олж өг гэсэн байна.

Миний ажил ч ингээд л багагддаггүй хүндээ гэснээр бид хоёрын яриа дууссан билээ.

**Д. Дондогдорж**

# Цагдан сэргийлэх байгууллагат туслах хүчнүүдийн тэргүүний сайчуудын аймгийн зөвлөлгөөн

БНМАУ—ын Цагдан Сэргийлэх байгууллага бол олон нийтийн хэв журмыг сахиулах, социалист төрийн захиргааны байгууллага мөн.

ЦС байгууллага нь улс, олон нийтийн байгууллагатай нягт холбоотой ажиллаж социалист хэв журам сахиулах явдалд хөдөлмөрчин олон түмнийг өргөн оролцуулах зорилгоор ЦС байгууллагат туслах олон нийтийн бригад, байцаагч зэрэг хөдөлмөрчин олны сайн дурын хүчин туслалцаанд түшиглэж ажилладаг билээ.

Тухайлбал: гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чухал үүргийг гүйцэтгэдэг. ЦС байгууллагат туслах олон нийтийн бригад, галын аюулаас сэргийлэн хамгаалах сайн дурын бүлгэм, гал эсэргүүцэх инженер техникийн комисс, улсын авто техникийг шалган байцаах газрын ажилд туслах олон нийтийн байцаагч зэрэг туслах хүчнүүдийн өндөр сонор сэрэмж, өргөн туслалцаанд түшиглэн ажилладагт оршино.

Аймгийн Намын Хороо, АДХГ Захиргаа, ЦС байгууллагат туслах хүчнүүдийн тэргүүний сайчуудын улс, аймгийн зөвлөлгөөнийг бэлтгэн явуулах тухай асуудлыг хэлэлцэж энэ ажлыг эрхлэх комиссыг байгуулан ЦС байгууллагат туслах хүчнүүдийн тэргүүний сайчуудын аймгийн зөвлөлгөөнийг өнөөдөр аймгийн төв Зуунмод хотод хийлгэж байгаа нь ЦС байгууллагын ажилтнууд,ЦС байгууллагат туслах хүчнүүдийн улс төр хөдөлмөрийн идэвхийг улам өрнүүлж байна.

МАХН—ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо, Намын байгууллагаас ЦС байгууллагат туслах олон нийтийн бригадыг удирдах ажлыг сайжруулах тухай гаргасан тогтоолдоо: «Манай ардчилсан төрийн чухал үүрэг нийгмийн хэв журмыг сахиулах ажилд хөдөлмөрчдийн сайн дураараа оролцож байгаа энэ хэлбэрийг цаашид хөгжүүлэн бэхжүүлж энэ ажилд намын байгууллагаас тавих хяналт удирдлагыг тодорхой болгож сайжруулах нь чухал байна» гэжээ.

Манай нам, засгаас авч явуулж байгаа арга хэмжээний үр дүнд ЦС байгууллагат туслах хүчнүүд зохион байгуулалтын хувьд өргөжиж түүний гишүүдийн идэвх санаачлага, үүрэг хариуцлага улам өсөн нэмэгдэж байна.

Одоо тус аймгийн хэмжээгээр ЦС байгууллагат туслах олон нийтийн бригад, штаб 70 шахам,галын аюулаас сэргийлэн хамгаалах сайн дурын бүлгэм, гал эсэргүүцэх инженер техникийн комисс 140 орчим байгаа бөгөөд түүний гишүүдээр олон зуун хүн ажиллаж байна.

Мөн галын ба авто техникийг шалган байцаах газрын ажилд туслах олон арван байцаагч нар ажилладаг юм.

Эдгээр хүчнүүд бол гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах, социалист ба ард иргэдийн амины өмчийг гал түймрийн аюулаас хамгаалах, авто хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар чухал үүрэг гүйцэтгэж байна.

Энэ чанараараа ЦС байгууллагат туслах хүчнүүдийн тэргүүний сайчуудын улс, аймгийн зөвлөлгөөнд оролцох болзлыг хангаж ажил хөдөлмөрөөрөө шалгарсан сайчууд юуны өмнө аймгийн зөвлөлгөөнд хуран цугларч ажлын дэвшилт арга барил, баялаг туршлагаа харилцан солилцож байна.

Үүнд: ЦС байгууллагат туслах олон нийтийн бригадын гишүүн, хүний бага эмч Лувсанжамц, Баянчандманий хороо захиргааны харъяат эмэгтэй Ханд, галын аюулаас хамгаалах сайн дурын бүлгэмийн гишүүн, аймгийн төвийн Артелийн ажилчин Банзрагч, Баянзүрх сумын ой хамгаалагч Сандагдорж, Авто техникийн олон нийтийн байцаагч, Их Хайрханы уулын үйлдвэрийн ажилчин Намсрай, Баянчандмань дахь дундын засварын газрын ажилчин Дамбадаржаа нарын зэрэг олон тооны сайчуудыг дурьдаж болно.

Тэргүүний ажилтай бригад комисс,гишүүдийн тоо олширч байгаа боловч зарим нэгэн бригад, гишүүд ба галын бүлгэм,комиссын ажил жигд сайжирч чадаагүй байгаад зохих дүгнэлт хийх явдал шаардагдаж байна.

ЦС байгууллагын ажилд туслах хүчнүүдийн өмнө зогсож байгаа гол зорилго бол гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажлыг манай одоогийн хөгжлийн шаардлагад зохицуулан эрс сайжруулахын хамт социалист өмчийг хамгаалах. эд хөрөнгө, барилга төхөөрөмж, ой билчээрийг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, авто ба хөдөө аж ахуйн машин механизмын арчлалт ашиглалт, хөдөлгөөний байдалд тавих хяналт шалгалтыг эрс сайжруулж, үр бүтээлтэй дайчин шуурхай болгох явдал мөн.

Үүний тулд тэргүүний сайчуудын туршлагыг бүх нийтийн хүртээл болгохын зэрэгцээгээр ЦС байгууллагат туслах хүчнүүдийн хууль эрхийн мэдлэгийг эрс дээшлүүлж тус тусын дүрмээр тавигдсан эрх үүргийг эзэмшүүлж аймгийн ЦС ба орон нутгийн нам, улсын байгууллагын удирдлага туслалцааг нэгэн адил сайжруулах явдал чухал байна.

**О.Лхамсүрэн**